

1.1.2	БГТ- 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, ЭМДС-ийн статистик мэдээллийг эмхэтгэл болгон хэвлүүлж олон нийтийг мэдээллээр хангана.	-	Эмхэтгэлийн тоо, Цахим хандалтын тоо	Эрүүл мэндийн даатгалын 2022 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг бэлтгэсэн.	Эрүүл мэндийн даатгалын 2022-2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг эмхэтгэл болгон хэвлүүлж, түгээсэн байна.	I-II улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
1.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3-т заасан “Цахим шилжилтэд бүрэн шилжинэ” зорилтын хүрээнд:							
1.2.1	БГТ- 1.3.2 E-Mongolia хөтөлбөрөөр дамжуулан үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлж, олон нийтэд сурталчлан, таниулна.	-	Сурталчилсан контентын тоо	13А маягтыг цахимаар илгээдэг болсонтой холбогдуулан 19 постер, мэдээ-2, рийл-1, ЭМД-аараа авсан тусламж, үйлчилгээний мэдээллээ харах боломжтой талаар нийт 7 постер бэлтгэн, сурталчилсан.	E-Mongolia хөтөлбөрөөр дамжуулан үзүүлэх үйлчилгээнүүдийг олон нийтэд сурталчлан, таниулсан байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
1.2.2	БГТ- 1.3.4 E-Daatgal rap утасны аппликэйшний нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэж, олон нийтэд сурталчлан, таниулна.	-	Сурталчилсан контентын тоо	E-Daatgal rap утасны аппликэйшнийг 2020 оноос нэвтрүүлсэн. Хөгжүүлэлт хийхээр түр хаасан байгаа.	E-Daatgal rap утасны аппликэйшний үзүүлэх үйлчилгээнүүдийг олон нийтэд сурталчлан, таниулсан байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
2.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө” зорилтын хүрээнд:							
2.1.1	БГТ-4.1.8 Улсын хэмжээнд даатгуулагч-иргэн, гэрээт байгууллагуудын сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэн, байгууллагын тоо	Судалгаанд нийт 7830 иргэн-даатгуулагч, эрүүл мэндийн байгууллага хамрагдан, үр дүнг тооцсон.	- Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцсон байна. - Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг судалгаатай уялдуулсан байна.	II-IV улирал	Хэрэглэгчтэй харилцах төвийн мэргэжилтнүүд

	БГТ-4.1.9 Иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлан таниулах цогц арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.	450 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Цогц арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт 90 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний арга хэмжээний хэрэгжилт 95 хувиас доошгүй байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
2.1.2	БГТ-4.1.10 Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсанд хандсан даатгуулагч-иргэдэд эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээлэл хүргэж, санал гомдлыг шийдвэрлэнэ.	-	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	Лавлах утсанд ирсэн 111,992 дуудлага, эргэн холбогдсон дуудлага 6822, биечлэн ирсэн 1307 даатгуулагч-иргэдэд холбогдох асуудлын дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.	Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсанд хандсан даатгуулагч-иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, санал гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.	I-IV улирал	Хэрэглэгчтэй харилцах төвийн мэргэжилтнүүд
2.1.3	БГТ-4.1.11 Байгууллагын үйл ажиллагаа, даатгуулагчийн эрх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаарх нэгдсэн мэдээ, мэдээллийг сургалт сурталчилгааны бүхий л төрлийг ашиглан бэлтгэж, олон нийтэд түгээж, мэдээллийн ил тод байдлыг хангуулна.	-	Бэлтгэсэн контентын тоо	Албан ёсны цахим хаягуудаар нийт 1643 контент бэлтгэн, түгээсэн.	Шаардлагатай контентуудыг бэлтгэж, иргэдэд түгээсэн байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
			Хандалтын тоо	9 сая 260 мянган хүнд хүрсэн	Хандалт нэмэгдсэн байна.		
2.1.4	БГТ-4.1.12 “Хэрэглэгчтэй харилцах төв”-өөр үйлчлүүлсэн даатгуулагч-иргэдийн сэтгэл ханамж, иргэд, олон нийтийг бодит, үнэн	-	Судалгаа тайлан	“Хэрэглэгчтэй харилцах төв”-өөр үйлчлүүлсэн даатгуулагч-иргэдийн сэтгэл ханамжийн	Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцсон байна.	I-IV улирал	Хэрэглэгчтэй харилцах төвийн мэргэжилтнүүд

	зөв мэдээллээр хангахад чиглэгдсэн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.			судалгаа 2 удаа авч, үр дүнг тооцсон .			
2.1.5	БГТ-4.1.13 Даатгуулагчаас цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журмыг хэрэгжүүлэх, Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах" 11-11 төвд нийт 829 санал, хүсэлт ирснийг 100 хувь барагдуулсан.	"Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг хүлээн авч бүрэн барагдуулан ажилласан байна.	I-IV улирал	Хэрэглэгчтэй харилцах төвийн мэргэжилтнүүд
2.1.6	Эрүүл мэндийн даатгалын тухай болон холбогдох хуулийг сурталчлах, даатгалын орлого, хамралтыг нэмэгдүүлэх нээлттэй өдөрлөг болон сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	ЭМДС	Сургалт зохион байгуулсан тоо	Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө-3, арга хэмжээ-2, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 8 удаа, оюутан, суралцагчдад 4 удаа, нээлттэй өдөрлөг аян 2, сурталчилгааны чиглэлээр 4 удаагийн сургалт зохион байгуулав.	Нээлттэй өдөрлөг болон сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
2.1.7	Салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай, нээлттэй ил тод сурталчилж, даатгуулагч иргэдийг бодит мэдээллээр хангах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага болон хуулийн этгээдтэй хамтран ажиллана.	ЭМДС	Гэрээ байгуулсан байгууллагын тоо	Тушаал-9 Гэрээ 28 Гэрээ дүгнэсэн акт -27	Хэвлэл мэдээллийн байгууллага болон хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд

2.1.8	Хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан эрүүл мэндийн даатгалын мэдээ, мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэх, мэдээллийн хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлж, сурталчилна.	-	Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нэвтрүүлгийн тоо	Нийт 177 удаагийн ярилцлагаас телевиз 103, вэбсайт 68, радио-6.	Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан байгууллагын удирдлага, албан хаагч, мэргэжилтнүүдийг холбож, ярилцлага, тодруулга өгсөн байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
2.1.9	Хэвлэлийн мониторинг хийж, хариу арга хэмжээ авч, тайлагнана.	-	Мониторинг хийгдсэн мэдээ, мэдээллийн тоо	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан 2971 мэдээ, мэдээлэлд мониторинг хийж, үр дүнг удирдлагад тайлагнасан.	Мэдээ, мэдээллийн тоо, агуулгын анализ хийгдсэн байна.	I-IV улирал	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд
2.1.10	Байгууллагын цахим хуудсуудад иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч ажиллана.	-	Чатанд хандсан хэрэглэгчийн тоо	Коммент-480 Чат-15,242	Албан ёсны цахим хаягуудад хандсан чат, комментод хандсан асуултад түргэн шуурхай, үнэн зөв, бодитой мэдээлэл өгсөн байна.	I-IV улирал	Хэрэглэгчтэй харилцах төвийн мэргэжилтнүүд

—oOo—